

Дашбал А.Буяннэмэх

УБИС-ийн докторант

**ОРЧИН ҮЕИЙН НИЙГМИЙН ФИЛОСОФИД
БИЕ ХҮНИЙГ СУДЛАХ ОНЦЛОГ
(Онолуудыг харьцуулан шинжлэх нь)**

Товчлол: Манай нийгмийн философи, социологийн ерөнхий онолын хүрээнд сүүлийн жилүүдэд бие хүнийг формацийн онолоор бараг дагнан судалж иржээ. Ингэхэд бие хүний мөн чанар нийгмийн харилцааны нийлбэр цогцос маягаар ойлгогдож байдаг.

Тэгвэл үйл ажиллагааны онол нь формацийн онолтой харьцуулахад тэрхүү нийгмийн харилцааны цаад гүнд нь байгаа хүний үйл ажиллагааг авч үзсэнээрээ онцлогтой. Үүний дүнд бие хүний асуудлыг илүү гүнзгий ойлгох боломжтой болох юм.

Түлхүүр үг:

Бие хүн, онолын плюрализм, компаратив арга, нийгмийн харилцаа, үйл ажиллагаа, субъект, объект.

Орчин үеийн нийгмийн философийн зохиол бүтээлүүдийг тоймлон авч үзвэл бие хүний асуудлыг хөндөөгүй нэг ч бүтээл байхгүй гэж хэлж болно. Энэ нь бие хүний асуудал нийгмийн философид ямаршуу байр суурь эзэлж байдгийг харуулж байгаа юм.

Бие хүний асуудал, ер нь хүний асуудал гүн ухаанд голлох байрыг эзлэн, хамгийн чухал асуудлуудын тоонд ордог байна.

Одоогийн нийгэм шинжлэлийн бие хүний судалгааны содон онцлог нь онолын олон урьгалч үзэл (плюрализм) ноёрхож буй явдал юм. Бие хүнийг судлах формацийн онол, шашны философийн үзэл баримтлалууд, нийгмийн дүрийн онол, элитийн онол, үйл ажиллагааны онол зэрэг олон онолын урсгал чиглэлүүд зэрэгцэн тогтнож байна. Энэ байдал нь ч нийгэм шинжлэлд эрүүл, жинхэнэ шинжлэх ухааны маргааныг өрнүүлэх, ингэснээр судалгаа шинжилгээний ажлыг алхам алхмаар урагшлуулах аятай боломжийг бүрдүүлж байгаа билээ.

Зохиогчийн баримталж буй байр суурь нь, бие хүний асуудлыг задлан шинжлэх онолын бүхий л чиглэлүүд өөр өөрийн гэсэн онцлогтой, асуудлыг тус тусын өвөрмөц баримтлал, арга зүйгээр тайлбарладаг бөгөөд нийгмийн философид тодорхой байр суурийг зэрэгцэн эзлэх эрхтэй гэж үзнэ.

Ийм учраас бас тодорхой онолуудыг хооронд нь харьцуулан дүгнэх аргаар (компаратив) оновчтой, үр ашигтай, дундаж мэдлэгийг гарган авч болох юм.

Манай монголын нийгэм шинжлэлийн олон салбарт онолын харьцуулсан судалгаа ихээхэн дэлгэрч байгаа билээ¹. Нийгмийн философийн хувьд, түүний нэг гол онол болсон бие хүний онолын хүрээнд ч эл аргыг хэрэглэж болмоор санагддаг юм.

Формацийн онолоор бид бие хний мөн чанарыг нийгмийн харилцааны цогцолбортой холбон тайлбарладаг. Энэ талаар энэхүү онолыг үндэслэгч К.Маркс олон бүтээлдээ дэлгэрэнгүй тайлбарласан байдаг².

Нийгмийн бүхий л харилцааны үндэс нь эдийн засгийн, үйлдвэрлэлийн харилцаанууд юм. Материаллаг баялаг үйлдвэрлэх, солилцох, хуваарилах, хэрэглэх үйл явцад үүсэн хөгжиж байдаг эдгээр объектив бодит харилцаа нь нийгмийн бүх харилцаагаа тодорхойлж, ингэснээрээ тухайн нийгмийн байгууллын бүтцийг тодорхойлно.

Ангит нийгэмд харилцаа нь өөр өөр сонирхол бүхий томоохон бүлэг хүмүүсийн хооронд байдаг тул ангийн шинжтэй. Нийгмийн харилцаа нь зөвхөн эдийн засаг, ангийн харилцаануудаар хязгаарлагддаггүй юм. "Капитал" зохиолд XIX зууны хөрөнгөтний нийгмийн байгуулал нь ахуйн тал, нийгэм зүйн (социаль) асуудлууд, улс төр, үзэл суртлын давхарга, гэр бүлийн харилцаа зэрэг олон тал харилцаануудын нийлмэл байдалтай дүрслэгджээ. Энэ бүх харилцаанууд нь тухайн бие хүнийг тодорхой төрхтэй болгон төлөвшүүлдэг.

Хүн төрөлхтний нэгээхэн хэсгийн түүхэн бодит үзэгдэл болж байсан социалист нийгмийн үед ч тухайн нийгмийн харилцаа нь бие хүнийг өөрийн хэв маягаар төлөвшүүлж байсан юм. Үгүй ядахдаа хүнийг энэ маягаар хүмүүжүүлэхэд чиглэгдэж байлаа.

Нийгмийн түүхэн тодорхой харилцааны бүхэллэг цогцос нь өмнөх үеийн харилцаануудын суурин дээр түүнийг диалектикчаар үгүйсгэн бий болсон байдаг тул бие хүн нь зөвхөн орчин үеийн бүтээгдэхүүн болоод зогсохгүй, түрүү үеийн түүх-соёлын өвийг залгамжлагч болдог байна. Учир иймд формацийн онолоор бие хүнийг зайлшгүй түүхэн хөгжилтэй холбон авч үздэг юм³. Формацийн онол нь түүхэн тодорхой нийгэм-эдийн засгийн байгуулал бүрт төлөвшдөг бие хүний хэв маягийг тодорхойлоход тун чухал үндэс суурь болдог онол болно.

Манай нийгэм судлаачид XX зууны II хагасын турш энэхүү онол-арга зүй дээр тулгуурлан монголын нийгмийн хөгжлийн, түүний дотор бие хүний суурь судалгаануудыг явуулсан билээ. Жишээ нь, 1984 онд Улаанбаатар хотноо хэвлэгдсэн "БНМАУ-ын нийгмийн

¹ Жишээ нь: Монголын улс төр судлалд олон улс төрийн онолуудыг компаратив аргаар харьцуулан судлах судалгаа эрчимтэй хийгдэж байна. Энд Ц.Ганболд, Л.Пүрэвдорж зэрэг олон зохиогчдыг дурдаж болох юм.

² Маркс.К, Энгельс.Ф. Соч. -Т.3 гэх зэрэг олон бүтээл бий.

³ Зохиогчийн энэ талаар тодорхой бичсэн өгүүлэлтэй танилцаж болно. / Ховд дахь УБИС-ийн ЭШБичиг. -УБ., 1987 / А.Буяннэмэх. Бие хүнийг судлах түүхэн зарчим. - 149-156 дахь тал

бүтэц” гэдэг бүтээлд Монголын феодалын байгууллын үеийн анги, нийгмийн давхраажилтын асуудлыг авч үзсэн юм. Феодал ангийг хар, шар хэмээн ангилаад, язгууртан тайж нар дээр тулгуурладаг хар феодал буюу засаг ноёдыг зэрэг дэвээр нь хан, ван, бэйл, бэйс, гүн гэх мэтээр нарийвчлан хэв маягийг тогтоосон байна.

1921 оны Ардын хувьсгалаас өмнө лам нарын давхраа нийгмийн бүтцэд томоохон байр суурийг эзэлж, засаг төрийн хэрэгт ихээхэн нөлөөтэй байв. Гэвч бүх лам нарыг феодал хэмээн үзэж болохгүй ба дотор нь дээд лам нар (хутагт, хувилгаад), дунд болон доод лам нар гэж ялгаж болохыг тэмдэглэжээ. Эндээс зөвхөн дээд лам нарыг ноёлогч ангид хамааруулж байна.

Хувьсгалын өмнөх монголын үндсэн ангийн нэг бол ард анги бөгөөд, тэр нь дотроо сум ард (төрийн данстай), хамжилга (угсаа залгамжилсан ноёдын), шавь (дээд лам нарын) гэж хуваагдаж байлаа⁴. Ингэхлээр тэр үеийн бие хүн нь энэ анги, давхраажилтын ялгаатай салшгүй холбогдож, аль нэгнийх нь төлөөлөгч болж байдаг.

Бие хүний түүхэн хэв маягийн ийм тодорхойлолт, мөн суурь судалгааг зөвхөн формацийн онол-арга зүй дээр тулгуурлан явуулах боломжтой юм.

Нийгмийн философийн бие хүнийг судалдаг өөр бас нэг онол бол нийгмийн дүрийн онол болж байдаг. Энэхүү онолыг анх 1930-аад оны үед америкийн социологич, нийгэм судлаачид Р.Линтон, Ж.Мид нар санал болгон дэвшүүлсэн юм⁵. Тэдний үзсэнээр нийгмийн дүрийн ойлголт нь бодгаль, нийгэм хоёрыг холбож байдаг байна. Бодгаль нийгэмд оршин буй хэм хэмжээтэй дасан зохицох үйл явц өрнөнө.

Нийгмийн дүрийн онолын формацийн онолын ялгагдах онцлог нь бие хүний хэв маягийг судлахад бус харин түүний хувийн төрхөд гол анхаарлаа хандуулдаг. Хэрвээ хүмүүс бие биентэйгээ ялгагдах юмгүй, адилхан байсан бол бие хүний асуудал огт тавигдахгүй байсан биз ээ. Оросын эрдэмтэн И.С.Кон бичихдээ, Иван Иванович Ивановыг тодорхойлоход, юуны өмнө түүний нийгэмд гүйцэтгэж буй олон дүр, үүргийг тоочдог гэжээ. Идэр дунд насны эр хүн, багш, гэр бүлийн тэргүүн, хүүхдийн эцэг, уран сайханч, сайн найз гэх мэт.

Ингэхлээр дүрийн онолд нийгмийн дүрийн тухай ойлголт маань голлох үүрэгтэй байдаг байна. Нийгмийн дүр бол нийгмийн тогтолцооны хүрээнд амьдрал үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүсийн зан үйл, аашлахуйн (поведение) хэм хэмжээний цогцос юм⁶. Хүмүүсийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, дүр нь эхнээсээ

⁴ БНМАУ-ын нийгмийн бүтэц –УБ., 1984 үзнэ үү.

⁵ Ж.Мид (1863-1931) Америкийн философич, социологич, нийгмийн философич хүн юм. Прагматизмын дараах үеийн төлөөлөгч болж байдаг. Хүний “Би”, нийгмийн субъект, хүмүүсийн хоорондын харилцааны асуудлаар (харилцаамж, общение, interaction) барууны сонгодог зохиогчдын нэг болно. Гол бүтээлүүд нь: Mind, Self and Society – Chic., 1936; The philosophy of the act. –Chic., 1938.

⁶ Кон И.С. Социология личности. –М., 1967; Мөн түүний Открытие “Я” –М., 1978 зохиолуудыг үзнэ үү.

“программчлагдсан”, гадаад жүжиглэл маягтай ойлгогддог нь энэхүү онолын доголдолтой тал нь болдог юм. Тэгвэл үйл ажиллагааны онол нь хүний зан үйл, идэвхи, үүргийн дотоод механизмыг шинжлэн судлахад анхаарлаа хандуулдагаараа ялгагдана.

Үйл ажиллагааны онол нь нийгмийн амьдрал, түүний дотор бие хүний асуудлыг “үйл ажиллагаа”-ны ойлголт дээр тулгуурлан тайлбарлана. Нийгмийн амьдрал нь хамгийн гол утгаараа хүмүүсийн үйл ажиллагаа, түүний олон хэлбэр дүрсүүдийн илэрхийлэл болж байдаг. Асуудлыг ингэж тавьснаар “үйл ажиллагаа”, “нийгмийн харилцаа” гэсэн хоёр ойлголтын харьцааны асуудал зайлшгүй яригдана. Учир нь формацийн онолд нийгмийн мөн чанар, түүний дотор бие хүний мөн чанарыг нийгмийн харилцааны нийлбэр цогцостой холбон тайлбарласан байдаг билээ.

Нийгмийн харилцаа нь хүний үйл ажиллагааны үр дүн болж, түүгээр байнга нөхөн сэргээгдэж байдаг. Үйл ажиллагаа бол хүмүүсийн хамтын үйл ажиллагаа болж байдаг тул тэрхүү хамтын шинж чанарын бүтэц, зохион байгуулалтын илэрхийлэл нь нийгмийн харилцаа юм⁷.

Ингэхлээр хүний мөн чанарыг нийгмийн харилцааны нийлбэр цогцос гэж үзээд зогсохгүй, энэ үндэслэлийг гүнзгийрүүлэн үйл ажиллагаатай холбон тайлбарлаж байна. Нийгмийн үйл ажиллагааны онол нь хүнийг нийгмийн бүх асуудлын төвд тавьдаг юм.

Хүн бол юуны өмнө дотооддоо идэвхийг агуулагч, үйл ажиллагааг “тээгч” мөн. Энэ утгаар нь хүнийг “субъект” гэж тодорхойлно. Үйл ажиллагаа бол хүний оршин тогтнох арга, түүний отрибутив шинж юм. Үйл ажиллагаа нь нийгмийн, ухамсар зорилго чиглэлтэй, үйлдвэрлэн бүтээх, юмсаг, зүй тогтолт, объектив шинжтэй байдаг.

Энд нэг гол зүйлийг анхааруулахад “субъект” гэдэг ойлголт нь “субъектив” гэдэг ойлголтоос зарчмын хувьд ялгагддаг юм. “Объектив”, “субъектив” гэдэг ойлголтууд нь бодит ертөнцийн мөн чанарыг илэрхийлэхэд зориулагдсан бөгөөд “объектив” нь хүний субъектив ухамсраас үл хамааран оршдог бодит байдлыг тэмдэглэдэг. Хүн буюу субъект нь бодит юмсын нэг нь болдгоороо объектив шинжтэй бөгөөд харин материйн хөгжлийн дээд өвөрмөц хэлбэр болохын хувьд субъектив байдлаар тусгах чадварыг давхар эзэмшиж байдаг юм. Ийм учраас субъект нь өөрийн мөн чанараараа объектив шинж чанартай бөгөөд, субъектив тусган илэрхийлэх, танин мэдэх чадвар нь түүний нэг шинж болж байна.

Ийм утгаар нь хүнийг зохион байгуулалт, бүлэглэх хүрээгээр нь олон субъект болгон ангилж хувааж болно. Эрдэмтэн

⁷ Энэ талаар Фофанов В.П. Социальная деятельность как система. –Новосибирск, 1981; Сагатовский В.Н. Категориальный контекст деятельностного подхода /Деятельность: теории, методологии, проблемы. –М., 1990 номонд; Момджян К.Х., Вербин А.И. нарын зохиол бүтээлийг харна уу.

С.Т.Мелюхин хүнийг материйн хэлбэр болохынх нь хувьд бие хүн, гэр бүл, хамт олон, нийгмийн бүлэг, анги, төр улс, улсуудын холбоо, хүн төрөлхтөн гэх мэт хамрах хүрээгээр нь ангилсан нь бий⁸.

Бидний сонирхож буй асуудал нь зөвхөн бие хүний хүрээгээр хязгаарлагдаж байгаа учраас бие хүнийг үйл ажиллагааны субъект гэж авч судлах юм. Ингэснээр бие хүний судалгаанд задлан шинжлэлийн шинэлэг чиглэлийг төлөвшүүлэх боломжтой болно.

Резюме

Изучение проблем личности всегда было одним из главных направлений в нашей социальной философии.

Но в рамках социальной философии существуют целый ряд теории, которые исследуют вопросы, связанные с человеческой личностью. Поэтому вызывает определенный интерес сравнительного (компаративного) анализа этих теорий по проблеме личности, к чему посвящена эта статья.

Ном зүй:

1. Деятельность: теории, методологии, проблемы. М., 1990
2. Фофанов В.П. Социальная деятельность как система. Новосибирск., 1981
3. Кон И.С. Открытие "Я". М., 1978

⁸ Мелюхин С.Т. Материя в ее единстве, бесконечности и развитии. –М., 1966